

ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2015 ОНЫ 2-Р УЛИРАЛД (СУМДАД)

Мониторингод хамруулсан 21 сумын ЗДТГ 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, орлого, зарлагын гүйлгээ, тэдгээрт холбогдох шийдвэр, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг нийтэд мэдээлэх байдал нэмэгдэж байна.

НИЙТЭД ИЛ БОЛСОН МЭДЭЭЛЭЛ

НИЙТ МЭДЭЭ, ШИЙДВЭР

1 улиралд 194 → 2 улиралд 238

МЭДЭЭ


1 улиралд 147 → 2 улиралд 174

ШИЙДВЭР


1 улиралд 47 → 2 улиралд 64

Дорнод аймгийн Хэрлэн сумын ЗДТГ хамгийн олон мэдээ, шийдвэр нийтэлжээ. Харин Баян-Өлгий аймгийн Өлгий, Архангай аймгийн Эрдэнэбулган, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар зэрэг 10 гаруй сумын ЗДТГ цөөн мэдээ нийтэлсэн ба шийдвэрээ огт ил тод болгоогүй байна.

НИЙТ МЭДЭЭНИЙ ТОО




НИЙТ ШИЙДВЭРИЙН ТОО



НИЙТ МЭДЭЭ, ШИЙДВЭРИЙН ТОО (САРААР)

Сумдын ЗДТГ 5-р сард хамгийн олон мэдээ (70) нийтэлсэн бол 6-р сард хамгийн олон шийдвэр (33) нийтэлжээ.



Хамруулсан мэдээлэл, ашигласан мэдээллийн хэрэгсэл

2015 оны 4 дүгээр сарын 1-ээс 7 дугаар сарын 15-ны хооронд хийсэн мониторингод хамруулсан мэдээлэл

- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг /хуулийн 6.4.4 дэх заалт/
- Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ тус бүрийн агуулга, хүлээн авагчийн нэр /хуулийн 6.4.5 дахь заалт/
- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд холбогдох шийдвэр /хуулийн 6.10 дахь заалт/
- Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ /хуулийн 6.1.2 дахь заалт/

Ашигласан мэдээллийн хэрэгсэл



Шилэн дансны нэгдсэн цахим хуудас



ЗДТГ-ын цахим хуудас



ЗДТГ-ын мэдээллийн самбар

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг орон нутагт хэрхэн хангаж байгаад Нээлттэй Нийгэм Форумгаас иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран мониторинг хийж дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.